



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/052/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>НТАГ-ын дэд дарга Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>СНАХ-ийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас:315558 Цахим хаяг:gantugss@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 03.14 № 01/295
танай _____-ны № _____-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН ТӨВ
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.МӨНХ-ЭРДЭНЭ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх дүүргийн Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянзүрх дүүргийн Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв ОНӨААТҮГ нь тайлант онд 8,395,040.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 12,748,074.1 мянган төгрөгийн зардал гарган, 4,353,034.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус үйлдвэрийн газар тайлант онд 1,050.4 мянган м.кв нийтийн эзэмшлийн шороон зам хусан тэгшилж, 2000м.кв явган зам, 3 усан оргилуур, 30 талбайн эвдрэл гэмтлийг засаж, 5 хорооны автобусны буудал, сагсан бөмбөгийн 3 талбай, 3 элчин сайдын яамны харуулын байрыг тохижуулж, эрсдэл ихтэй хороодод

үерийн ус соруулах, далан сэргээх, лаг цэвэрлэх, булгийн ус, мөсний халиа гэх мэт ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудал

Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 113.0 хувийн гүйцэтгэлтэй гэж Баянзүрх дүүргийн засаг дарга дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	2023оны 12-р сарын 31	2024оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,335,765,793.20	2,560,563,545.45
1.1.4	Бусад авлага	-	696,000.00
1.1.6	Бараа материал	7,368,425,302.90	797,922,888.17
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,704,191,096.10	3,359,182,433.62
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	906,275,416.68	928,136,283.24
1.2.2	Биет бус хөрөнгө	4,083.37	-
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	906,279,500.05	928,136,283.24
1.3	НИЙТ ХӨРӨНГӨ	11,610,470,596.15	4,287,318,716.86
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	629,131,644.65	603,846,880.80
2.1.1.3	Татварын өр	-	696,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,945,529,145.03	-
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,574,660,789.68	604,542,880.80
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,574,660,789.68	604,542,880.80
2.3	Эздийн өмч	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,035,809,806.47	3,682,775,836.06
2.3.20	Эздийн өмчийн дүн	8,035,809,806.47	3,682,775,836.06
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	11,610,470,596.15	4,287,318,716.86

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,551,974,921.30	8,164,924,745.03
3	Борлуулалтын өртөг	-	10,283,354,192.53
4	Нийт ашиг (алдагдал)	4,551,974,921.30	(2,118,429,447.50)
6	Хүүгийн орлого	132,441,794.45	38,212,132.77
9	Бусад орлого	643,402,140.00	191,903,215.00
11	Ерөнхий ба удирдлагын зардал	5,327,818,855.75	2,464,719,870.68
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	(4,353,033,970.41)
20	Орлогын татварын зардал	-	-
21	Татварын дараах ашиг (алдагдал)	-	(4,353,033,970.41)
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(4,353,033,970.41)
24	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
28	Орлогын нийт дүн	-	(4,353,033,970.41)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,035,809,806.47	8,035,809,806.47
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-
3	Залруулсан үлдэгдэл	8,035,809,806.47	8,035,809,806.47
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,035,809,806.47	8,035,809,806.47
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-
11	Залруулсан үлдэгдэл	8,035,809,806.47	8,035,809,806.47
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,353,033,970.41)	(4,353,033,970.41)
13	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,682,775,836.06	3,682,775,836.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,070,329,600.00	5,257,607,732.77
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	4,070,329,600.00	5,257,607,732.77
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	8,248,886,780.40	6,071,022,113.29
1.2.1	Ажиллагчдад төлсөн	609,246,933.60	1,012,878,909.05
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	75,913,347.22	128,566,944.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,923,689,864.95	4,297,277,153.22
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	130,698,460.00	133,892,663.36
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	491,965,817.19	490,253,500.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,953,448.00	1,852,400.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	947,130.00	2,208,130.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	13,471,779.44	4,092,413.28
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,178,557,180.40)	(813,414,380.52)
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	132,441,794.45	38,212,132.77
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	132,441,794.45	38,212,132.77
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	132,441,794.45	38,212,132.77
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,046,115,385.95)	(775,202,247.75)
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,381,881,179.15	3,335,765,793.20
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,335,765,793.20	2,560,563,545.45

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2023 оны гүйцэтгэл	2024 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	4,551,974.9	5,514,185.6	8,164,924.8	(2,650,739.2)	148.1%
	Хүүгийн орлого	132,441.8	-	38,212.1	(38,212.1)	-
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	643,402.1	-	191,903.2	(191,903.2)	-
	Нийт орлого	5,327,818.8	5,514,185.6	8,395,040.1	(2,880,854.5)	152.2%
2	Нийт зардал	5,327,818.8	5,514,185.6	12,748,074.1	(7,233,888.5)	-
	Борлуулалтын өртөг	-	-	10,283,354.2		-
	Үүнээс: Удирдлагын зардал	5,327,818.8	5,514,185.6	2,464,719.9	3,049,465.7	-
3	Татварын өмнөх ашиг, алдагдал	-	-	(4,353,034.0)	4,353,034.0	-
4	Орлогын татвар	-	-	-	-	-
5	Цэвэр ашиг (алдагдал)	-	-	(4,353,034.0)	4,353,034.0	-
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	-	-	-	-	-
7	Төсөвт төлөх татвар, шимтгэл	197,379.1	-	331,130.8	(331,130.8)	-
	ХХОАТатвар	49,364.4	-	85,351.5	(85,351.5)	-
	АТӨЯХ-ийн албан татвар /3 төрлөөр/	2,557.5	-	1,354.4	(1,354.4)	-
	Нийгмийн даатгалын шимтгэл	145,457.2	-	244,424.9	(244,424.9)	-
8	Батлагдсан ажилтны тоо	45	50	41.0	9.0	82.0%
10	Нийт цалингийн сан	609,246.9	-	1,012,878.9	(1,012,878.9)	-
11	Нэг ажилтны дундаж цалин	1,130.0	-	1,361.0	(1,361.0)	-
14	Нийт авлага	-	-	696.0	(696.0)	-
15	Нийт өглөг	629,131.6	-	604,542.8	(604,542.8)	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,367.2 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 173,367.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17,853.9 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 173,367.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна.	1	173,367.2	-	-	1	173,367.2	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 64 нэр төрлийн 962,327.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгааг НӨХГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	3	173,367.2	-	-	1	173,367.2	2	-	-	-	-	-

Баянзүрх дүүргийн Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Тус үйлдвэрийн газар дүрмэндээ санхүүгийн тайлангийн бүрэлдхүүнийг "... 1.Санхүү байдлын тайлан, 2.Орлого үр дүнгийн тайлан, 3.Мөнгөн гүйлгээний тайлан, 4.Өмчийн өөрчлөлтийн тайлан,5.Төсвийн гүйцэтгэлийн тайлан, 6. Нэмэлт санхүүжилтийн тайлан,7.Санхүүгийн тайлангийн тодруулга, 8. Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл" гэж тодорхойлсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.1.санхүүгийн байдлын тайлан;8.1.2.орлогын дэлгэрэнгүй тайлан;8.1.3.өмчийн өөрчлөлтийн тайлан;8.1.4.мөнгөн гүйлгээний тайлан; 8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга." гэж заасантай нийцэхгүй байна.	1		-	-			1	-
Дүн	1		-	-			1	-